

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2020 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгийн өөрчлөлтийн тайлан	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	10
3.Аудитын тайлан.....	11
3.1. Ерөнхий зүйл.....	11
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй.....	11
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт	12
3.4. Материаллаг байдал	12
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	12
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт	13
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	14
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	14
3.9. Аудитын илрүүлэлт.....	15
Залруулсан алдаа.....	15
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил	15
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд	15
4. Менежментийн захидал	16
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	18



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ЮНЕСКО-ИЙН МОНГОЛЫН
ҮНДЭСНИЙ КОМИССЫН ЕРӨНХИЙ
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА С.УЯНГА
ТАНАА

2021.02.24 № 07/472
танай _____-ны № _____-т

Аудитын санал, дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу ЮНЕСКО-ийн Монголын үндэсний комиссын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

ЮНЕСКО-ийн Монголын үндэсний комиссын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 10 зорилтын хүрээнд 19 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 93.2 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	200,440,845.96	79,802,310.19
2	МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ	2,206,000.00	272,704.31
3	Кассад байгаа бэлэн мөнгө	2,206,000.00	272,704.31
6	Нэмэлт санхүүжилт	2,206,000.00	272,704.31
8	Банканд байгаа бэлэн мөнгө	-	-
9	Төгрөг	-	-
10	Төрийн сангийн харилцах	-	-
14	Нэмэлт санхүүжилтийн харилцах	-	-
27	АВЛАГА	49,607,144.26	55,466,087.18
28	Ажиллагсадтай холбогдсон авлага	-	7,822.28
30	Татаас санхүүжилтийн авлага	-	54,573,922.63
34	Бусад авлага	49,607,144.26	884,342.27
35	Байгууллагаас авах авлага	49,371,871.70	301,413.15
36	Хувь хүмүүсээс авах авлага	235,272.56	582,929.12
48	УРЬДЧИЛГАА	132,373,696.00	-
54	Урьдчилж гарсан зардал	132,373,696.00	-
60	БАРАА МАТЕРИАЛ	16,254,005.70	24,063,518.70
66	Хангамжийн материал	16,254,005.70	24,063,518.70
67	Бичиг хэргийн материал	999,716.00	1,224,300.00
70	Түлш шатах тослох материал	811,187.03	1,621,127.03
73	Бусад хангамжийн материал	14,443,102.67	21,218,091.67
86	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	172,943,906.29	148,458,174.87
106	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	172,943,906.29	148,458,174.87
108	Биет хөрөнгө	172,943,906.29	148,458,174.87
111	Авто тээврийн хэрэгсэл	55,000,000.00	55,000,000.00
112	Хуримтлагдсан элэгдэл	(55,000,000.00)	(55,000,000.00)
113	Машин, тоног төхөөрөмж	79,147,954.00	68,367,004.00
114	Хуримтлагдсан элэгдэл	(30,955,503.33)	(22,740,131.85)
115	Тавилга, аж ахуйн эд хогшил	89,575,147.00	89,575,147.00
116	Хуримтлагдсан элэгдэл	(18,849,365.40)	(27,960,555.28)
122	Бусад үндсэн хөрөнгө	56,300,941.00	56,252,541.00
123	Хуримтлагдсан элэгдэл	(2,542,766.98)	(15,303,330.00)
125	Номын фонд	267,500.00	267,500.00
127	Программ хангамж	770,000.00	770,000.00
128	Хасагдуулаг	(770,000.00)	(770,000.00)
137	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	373,384,752.25	228,260,485.06
138	НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	50,175,197.79	55,018,658.97
139	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	50,175,197.79	55,018,658.97
164	Өглөг	50,175,197.79	55,018,658.97
165	Ажиллагчидтай холбогдсон өглөг	222,754.00	154,488.23
170	Бусад өглөг	49,952,443.79	54,864,170.74
171	Байгууллагад төлөх өглөг	48,680,550.73	54,573,922.63
172	Хувь хүмүүст төлөх өглөг	1,271,893.06	290,248.11
214	ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	323,209,554.46	173,241,826.09
215	Засгийн газрын хувь оролцоо	323,209,554.46	173,241,826.09
216	Засгийн газрын оруулсан капитал /ЗГСан/ орон нутгийн сан	78,398,015.00	78,398,015.00
217	Өмч: -Төрийн өмч	78,398,015.00	78,398,015.00
223	Хуримтлагдсан үр дүн	244,811,539.46	94,843,811.09
224	Өмнөх үеийн үр дүн	244,811,539.46	244,811,539.46
225	Тайлант үеийн үр дүн	-	(149,967,728.37)
231	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	373,384,752.25	228,260,485.06

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Үзүүлэлт	Өмнөх онын гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл /төгрөгөөр/
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,129,744,416.56	600,280,709.90
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	962,858,616.56	423,953,709.90
Нийтлэг татварын бус орлого	962,858,616.56	423,953,709.90
Төсөвт байгууллагын өөрийн орлого	167,014,934.00	-
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	167,014,934.00	-
Бусад орлого	795,843,682.56	423,953,709.90
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	166,885,800.00	176,327,000.00
Улсын төвлөрсөн төсвөөс	166,885,800.00	176,327,000.00
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	166,885,800.00	176,327,000.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	833,206,137.25	750,248,438.27
УРСГАЛ ЗАРДАЛ	833,206,137.25	750,248,438.27
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	824,798,781.78	727,798,572.55
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	100,002,537.52	106,200,447.88
Цалин	72,743,537.96	81,029,750.02
Нэмэгдэл цалин	16,352,699.56	14,508,764.77
Унаа хоолны хөнгөлөлт	10,906,300.00	10,661,933.09
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	12,439,514.58	5,788,105.71
Тэтгэврийн даатгалын шимтгэл	8,553,214.63	4,145,273.61
Тэтгэмжийн даатгалын шимтгэл	837,427.57	235,050.35
ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	811,000.00	293,812.92
Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	215,369.15	58,762.59
Эрүүл мэндийн даатгалын хураамж	2,022,503.23	1,055,206.24
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	10,978,015.29	10,575,418.36
Байрны түрээс	10,978,015.29	10,575,418.36
Хангамж, бараа материалын зардал	6,434,725.53	7,338,044.00
Бичиг хэргийн материал	1,445,056.00	2,083,336.00
Тээвэр, шатахууны зардал	3,795,121.00	2,091,508.00
Шуудан холбоо интернэтийн төлбөр	1,194,548.53	3,163,200.00
Норматив зардал	-	18,884,646.00
Хоол	-	18,884,646.00
Томилолт, зочны зардал	435,800.00	409,199.86
Дотоод томилолтын зардал	246,700.00	-
Зочин төлөөлөгч хүлээн авах	189,100.00	409,199.86
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	22,404,909.87	294,729,154.82
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	20,968,409.87	292,192,654.82
Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	1,000,000.00	2,100,000.00
Даатгалын үйлчилгээний төлбөр	198,000.00	198,000.00
Тээврийн хэрэгслийн татвар	194,500.00	194,500.00
Тээврийн хэрэгслийн оношилгоо	44,000.00	44,000.00
Бараа үйлчилгээний бусад зардал	672,103,278.99	283,873,555.92
Бараа үйлчилгээний бусад зардал	660,406,666.52	248,427,894.50
Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	11,696,612.47	35,445,661.42
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	8,407,355.47	22,449,865.72
Бусад урсгал шилжүүлэг	7,301,500.00	-
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	7,301,500.00	-
Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,105,855.47	22,449,865.72
Төвлөрүүлэх шилжүүлэг	1,105,855.47	22,449,865.72
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)	296,538,279.31	(149,967,728.37)
НИЙТ ҮР ДҮН (VII=III+VI)	296,538,279.31	(149,967,728.37)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	1,011,425,033.29	654,854,632.53
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	15,000.00	-
Нийтлэг татварын бус орлого	15,000.00	-
Бусад орлого	15,000.00	-
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,011,410,033.29	654,854,632.53
Улсын төвлөрсөн төсвөөс	166,885,800.00	176,327,000.00
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	166,885,800.00	176,327,000.00
Нэмэлт санхүүжилтийн орлого	844,524,233.29	478,527,632.53
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)	1,009,219,033.29	656,787,928.22
УРСГАЛ ЗАРДАЛ	1,009,219,033.29	656,787,928.22
БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	952,116,127.09	579,764,139.87
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	100,611,914.48	106,397,921.73
Үндсэн цалин	73,341,914.48	81,227,223.87
Нэмэгдэл	16,352,700.00	14,508,764.77
Унаа хоолны хөнгөлөлт	10,917,300.00	10,661,933.09
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	12,439,514.58	5,788,105.71
Тэтгэврийн даатгалын шимтгэл	8,553,214.63	4,145,273.61
Тэтгэмжийн даатгалын шимтгэл	837,427.57	235,050.35
ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	811,000.00	293,812.92
Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	215,369.15	58,762.59
Эрүүл мэндийн даатгалын хураамж	2,022,503.23	1,055,206.24
Байр ашиглалтай холбоотой тогтмол зардал	10,578,100.00	10,575,418.36
Байрны түрээс	10,578,100.00	10,575,418.36
Хангамж, бараа материалын зардал	5,505,055.77	9,348,120.00
Бичиг хэрэг	908,800.00	3,020,920.00
Тээвэр, шатахуун	3,233,200.00	3,164,000.00
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,363,055.77	3,163,200.00
Норматив зардал	-	18,688,700.00
Хоол, хүнс	-	18,688,700.00
Эд хогшил, урсгал засварын зардал	-	10,943,440.00
Багаж техник хэрэгсэл	-	10,943,440.00
Томилолт, зочны зардал	752,100.00	409,199.86
Дотоод албан томилолт	246,700.00	-
Зочин төлөөлөгч хүлээн авах	505,400.00	409,199.86
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	23,587,200.00	309,323,004.64
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамж	22,150,700.00	306,786,504.64
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,000,000.00	2,100,000.00
Даатгалын үйлчилгээ	198,000.00	198,000.00
Тээврийн хэрэгслийн татвар	194,500.00	194,500.00
Тээврийн хэрэгслийн оношилгоо	44,000.00	44,000.00
Бараа үйлчилгээний бусад зардал	798,642,242.26	108,290,229.57
Бараа үйлчилгээний бусад зардал	798,642,242.26	108,290,229.57
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	57,102,906.20	77,023,788.35
Бусад урсгал шилжүүлэг	7,301,500.00	-
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	7,301,500.00	-
Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	49,801,406.20	77,023,788.35
Төвлөрүүлэх шилжүүлэг	1,120,855.47	22,449,865.72
Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	48,680,550.73	54,573,922.63
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	2,206,000.00	(1,933,295.69)
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	2,206,000.00	(1,933,295.69)
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	2,206,000.00
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	2,206,000.00	272,704.31

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

ҮЗҮҮЛЭЛТ	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн /төгрөгөөр/
2018 оны 12-р сарын 31-ээр үлдэгдэл	78,398,015.00	(51,726,739.85)	26,671,275.15
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	78,398,015.00	(51,726,739.85)	26,671,275.15
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз гарз	-	-	-
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-
Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/	-	296,523,279.31	296,523,279.31
2019 оны 12-р сарын 31-ээр үлдэгдэл	78,398,015.00	244,811,539.46	323,209,554.46
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	78,398,015.00	244,811,539.46	323,209,554.46
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз гарз	-	-	-
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-
Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/	-	(149,967,728.37)	(149,967,728.37)
2020 оны 12-р сарын 31-ээр үлдэгдэл	78,398,015.00	94,843,811.09	173,241,826.09

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	Дүн	Хувь
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-
I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	176,327,000.00	153,877,134.28	22,449,865.72	87.27
УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	176,327,000.00	153,877,134.28	22,449,865.72	87.27
Бараа, үйлчилгээний зардал	176,327,000.00	153,877,134.28	22,449,865.72	87.27
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	115,278,800.00	106,397,921.73	8,880,878.27	92.30
Үндсэн цалин	82,661,900.00	81,227,223.87	1,434,676.13	98.26
Нэмэгдэл	20,960,200.00	14,508,764.77	6,451,435.23	69.22
Унаа, болон бусад нөхөн олговор	11,656,700.00	10,661,933.09	994,766.91	91.47
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	15,562,800.00	5,788,105.71	9,774,694.29	37.19
Тэтгэврийн даатгал	10,951,500.00	4,145,273.61	6,806,226.39	37.85
Тэтгэмжийн даатгал	1,152,800.00	235,050.35	917,749.65	20.39
ҮОМШӨ ний даатгал	922,300.00	293,812.92	628,487.08	31.86
Ажилгүйдлийн даатгал	230,500.00	58,762.59	171,737.41	25.49
Эрүүл мэндийн даатгал	2,305,700.00	1,055,206.24	1,250,493.76	45.77
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	10,578,100.00	10,575,418.36	2,681.64	99.97
Байрны түрээс	10,578,100.00	10,575,418.36	2,681.64	99.97
Хангамж, бараа материалын зардал	7,305,200.00	7,232,200.00	73,000.00	99.00
Бичиг хэрэг	908,800.00	905,000.00	3,800.00	99.58
Тээвэр (шатахуун)	3,233,200.00	3,164,000.00	69,200.00	97.86
Шуудан холбоо, интернэтийн төлбөр	3,163,200.00	3,163,200.00	-	100.00
Томилолт, зочны зардал	752,100.00	409,199.86	342,900.14	54.41
Гадаад албан томилолт	505,400.00	-	505,400.00	-
Дотоод албан томилолт	246,700.00	-	246,700.00	-
Зочин төлөөлөгч хүлээн авах	-	409,199.86	(409,199.86)	-
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	24,325,300.00	21,796,086.79	2,529,213.21	89.60
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	21,788,800.00	19,259,586.79	2,529,213.21	88.39
Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	2,100,000.00	2,100,000.00	-	100.00
Даатгалын үйлчилгээ	198,000.00	198,000.00	-	100.00
Тээврийн хэрэгслийн татвар	194,500.00	194,500.00	-	100.00
Тээврийн хэрэгслийн оношилгоо	44,000.00	44,000.00	-	100.00
Бараа үйлчилгээний бусад зардал	2,524,700.00	1,678,201.83	846,498.17	66.47
Бараа үйлчилгээний бусад зардал	2,524,700.00	1,678,201.83	846,498.17	66.47
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	176,327,000.00	153,877,134.28	22,449,865.72	12.73
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	176,327,000.00	153,877,134.28	22,449,865.72	12.73
Улсын төсвөөс санхүүжих	176,327,000.00	153,877,134.28	22,449,865.72	12.73
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-	-	-
БАЙГУУЛЛАГЫН ТОО	-	-	-	-
АЖИЛЛАГСДЫН ТОО	9	9	-	100.00
Удирдах ажилтан	1	1	-	100.00
Гүйцэтгэх ажилтан	5	5	-	100.00
Үйлчлэх ажилтан	3	3	-	100.00

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Дүн	Хувь
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	2,206,000.00	(2,206,000.00)	-
I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	425,887,005.59	(425,887,005.59)	-
УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	-	425,887,005.59	(425,887,005.59)	-
Бараа, үйлчилгээний зардал	-	425,887,005.59	(425,887,005.59)	-
Хангамж, бараа материалын зардал	-	2,115,920.00	(2,115,920.00)	-
Бичиг хэрэг	-	2,115,920.00	(2,115,920.00)	-
Норматив зардал	-	18,688,700.00	(18,688,700.00)	-
Хоол, хүнс	-	18,688,700.00	(18,688,700.00)	-
Эд хогшил худалдан авах	-	10,943,440.00	(10,943,440.00)	-
Багаж, техник, хэрэгсэл	-	10,943,440.00	(10,943,440.00)	-
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	-	287,526,917.85	(287,526,917.85)	-
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	287,526,917.85	(287,526,917.85)	-
Бараа үйлчилгээний бусад зардал	-	106,612,027.74	(106,612,027.74)	-
Бараа үйлчилгээний бусад зардал	-	106,612,027.74	(106,612,027.74)	-
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	423,953,709.90	(423,953,709.90)	-
БУСАД ЭХ ҮҮСВЭР	-	423,953,709.90	(423,953,709.90)	-
Бусад орлого	-	423,953,709.90	(423,953,709.90)	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	2,206,000.00	(2,206,000.00)	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	272,704.31	(272,704.31)	-

3. Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд ЮНЕСКО-гийн Монголын үндэсний комиссын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг ЮНЕСКО-гийн Монголын үндэсний комиссын ерөнхий нарийн бичгийн дарга С.Уянга танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангах, төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх, холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 25-аас 2021 оны 02 дугаар сарын 25-ний хооронд Үндэсний аудитын газрын захиалгаар “Азуре Хүлүг Аудит” ХХК-ийн гүйцэтгэх захирал Г.Мөнхбаяр, чанарын хяналтын менежер С.Оюунцэцэг, аудитор П.Энхтуяа, аудиторын туслах П.Болортуяа, Б.Тамир нар хариуцаж хэрэгжүүлэв.

ЮНЕСКО-ийн Монголын үндэсний комисс нь 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газар болон “Азуре Хүлүг Аудит” ХХК-д 2021 оны 01 сарын 22-ны өдрийн МҮК/21/17 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

ЮНЕСКО-ийн Монголын үндэсний комиссын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Үйл ажиллагаанд монголын эрх ашгийг эрхэмлэн улс орны эдийн засаг, нийгмийн салбарт тавигдаж байгаа зорилтыг хэрэгжүүлэхэд нэмэр хандив оруулахыг чармайна.
- Юнеско-ийн үйл ажиллагаанд Монгол улсын идэвхтэй оролцоог хангаж боловсрол, шинжлэх ухаан, соёл, мэдээллийн салбарт түүний бүсийн төвүүд, үндэсний байгууллагатай хамтын ажиллагааг зохицуулна.
- Монгол орны түүх соёлын өв, дурсгалт зүйл, байгалийн өвөрмөц тогтоц, үнэт ховор баялаг, нөөцийг хайрлан арвижуулах, нөхөн сэргээх талаар ЮНЕСКО, түүний гишүүн орнуудтай нягт хамтран ажиллах чиглэлийг удирдлага болгоно.
- Дэлхий нийтийн боловсрол, шинжлэх ухаан, соёл, мэдээллийг хөгжүүлэхэд чиглэсэн бүхий үйл ажиллагааг идэвхтэй дэмжин улс түмний ойлголцол итгэлцлийг нэмэгдүүлэхэд тус төхөм үзүүлнэ.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Коронавируст халдвар /COVID-19/-ын цар тахлын улмаас Монгол Улсын Их Хурлаас 2020 оны 4 дүгээр сарын 09-ний өдөр дараах хуулиудыг баталсан. Үүнд:
 - Татварын алданги, торгуулиас чөлөөлөх тухай;
 - Хувь хүний орлогын албан татвараас чөлөөлөх тухай;
 - Нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх, ажилгүйдлийн даатгалын сангаас дэмжлэг үзүүлэх тухай;
 - Нийгмийн даатгалын шимтгэл төлөгчийг торгох шийтгэл, алдангиас чөлөөлөх тухай.

- “Төрийн жинхэнэ албаны албан тушаалын цалингийн сүлжээг тогтоох тухай” Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 75 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

ЮНЕСКО-ийн Монголын үндэсний комисс нь санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Гадаад харилцааны яамны Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газар 2020 онд ЮНЕСКО-ийн Монголын үндэсний комиссын санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгээгүй байна.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 730,025.6 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 7,300.2 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

ЮНЕСКО-ийн Монголын үндэсний комиссын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 145,124.3 мянган төгрөгөөр буюу 38.9 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс татаас санхүүжилтийн авлага, байгууллагаас авах авлага, хангамжийн материал, биет хөрөнгө болон урьдчилж гарсан зардлын дансанд материаллаг өөрчлөлт гарсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөг/ Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	2,206.0	272.7	(1,933.3)
Авлага	49,607.1	55,466.1	5,858.0
Урьдчилгаа	132,373.7	-	(132,373.7)
Бараа материал	16,254.0	24,063.5	7,809.5
Үндсэн хөрөнгө	172,943.9	148,458.1	(24,485.7)
Нийт хөрөнгө	373,384.7	228,260.4	(145,124.3)
Өр төлбөр	50,175.2	55,018.6	4,843.4
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	78,398.0	78,398.0	-
Нийт өр ба цэвэр хөрөнгийн дүн	373,384.7	228,260.4	(145,124.3)

Авлага дансны үлдэгдэл 55,466.1 мянган төгрөг болж, 5,858.9 мянган төгрөгөөр өссөн нь нэмэлт санхүүжилтийн үлдэгдлийг төсөвт татан төвлөрүүлснээс шалтгаалжээ. Тайлант онд цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэл, ХХОАТ-ын буруу тооцоололтой холбоотой

болон бусад хувь хүмүүсээс авах авлага 590.7 мянган төгрөг, татвар, нийгмийн даатгалын байгууллага болон шатахууны тооцооны авлага 301.4 мянган төгрөгийн байгууллагаас авах авлага бүртгэлтэй байна.

2019 онд ЮНЕСКО-ийн Парис дахь төвөөс оролцооны 4 хөтөлбөр хэрэгжиж эхэлсэн бөгөөд энэхүү хөтөлбөрт хамрагдан 179,673.7 мянган төгрөгийн төсөл хэрэгжихээс 2019 онд 47,300.0 мянга, 2020 онд 132,373.7 мянган төгрөгийн зарцуулалт хийгдсэнээр хөтөлбөр бүрэн хэрэгжиж дуусаж урьдчилж төлсөн зардал үлдэгдэлгүй болсон байна.

Бараа материалын дансанд үлдэгдэл 24,063.5 мянган төгрөг болж 7,809.5 мянган төгрөгөөр өссөн нь ном, товхимол, гарын авлага, судалгааны материал болон сургалт, сурталчилгааны тараах материалын үлдэгдэл өссөнөөс шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 148,458.2 мянган төгрөг болж 24,485.7 мянган төгрөгөөр буурсан нь компьютер, зөөврийн компьютер, принтер гэх мэт 21,740.8 мянган төгрөгийн үнэ бүхий 16 нэр төрлийн хөрөнгийг акталснаас шалтгаалжээ.

Өр төлбөр дансны үлдэгдэл 55,018.6 мянган төгрөг болж 4,843.4 мянган төгрөгөөр өссөн байна. Тайлант хугацаанд 54,573.9 мянган төгрөгийн татан төвлөрүүлэлт, цалин хөлстэй холбоотой 444.7 мянган төгрөгийн богино хугацаат өр төлбөр байна.

Тайлант онд Засгийн газрын оролцоо дансанд өөрчлөлт ороогүй байна.

Тус байгууллагын үйл ажиллагааны нийт орлого өмнөх оноос 529,463.7 мянган төгрөгөөр буюу 46.9 хувиар буурсан байна. Тайлант онд улсын төвлөрсөн төсвөөс 176,327.0 мянган төгрөгийн орлогын санхүүжилт авсан нь өмнөх оноос 9,441.2 мянган төгрөгөөр өссөн бол нэмэлт санхүүжилтийн орлогоор 423,953.7 мянган төгрөгийн санхүүжилт авсан нь өмнөх оноос 371,889.9 мянган төгрөгөөр буурсан байна.

Нийт зардал өмнөх оноос 82,957.7 мянган төгрөгөөр буюу 10.0 хувиар буурсан байна. Тайлант онд цалин хөлс болон нэмэгдэл урамшлын зардал 6,197.9 мянган төгрөг, хангамж бараа материалын зардал 903.3 мянган төгрөг, хоол хүнсний зардал 18,884.6 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж 272,324.2 мянган төгрөг, төвлөрүүлэх шилжүүлэг 21,344.0 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэн бол ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 6,651.4 мянган төгрөг, байр ашиглахтай холбоотой тогтмол зардал 402.6 мянган төгрөг, томилолт, зочны зардал 26.6 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 388,229.7 мянган төгрөгөөр тус тус буурч, тайлант онд 149,967.7 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 203,907.3 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 203,907.3 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 27,518.4 мянган төгрөгөөр бууруулж 176,388.9 мянган төгрөгөөр баталсан байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 27 хөтөлбөрийн арга хэмжээг санхүүжүүлэхээр 176,327.0 мянган төгрөгийн төсөв батлуулснаас гүйцэтгэлээр 153,877.1 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 22,449.8 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 153,877.13 мянган төгрөг буюу 87.3 хувьтай байгаа нь Коронавируст халдвар /COVID-19/-ын цар тахлын улмаас Монгол Улсын Их Хурлаас 2020 оны 4 дүгээр сарын 09-ний өдөр баталсан Нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх, ажилгүйдлийн даатгалын сангаас дэмжлэг үзүүлэх тухай хуулийн дагуу тэтгэвэр, тэтгэмж, ажилгүйдэл болон үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын шимтгэлийг чөлөөлсөнтэй холбоотойгоор ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлыг 9,774.7 мянган төгрөгөөр хэмнэсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

ЮНЕСКО-ийн Монголын үндэсний комисс нь 2020 онд ЮНЕСКО-ийн Бээжин дэх төлөөлөгчийн газар, Швейцарын хөгжлийн агентлаг, Солонгосын үндэсний комисс зэрэг байгууллагуудтай хийсэн гэрээний дагуу, мөн Хятадын Zhejiang хэвлэлийн компанийн санхүүжилтээр 478,527.6 мянган төгрөгийн нэмэлт санхүүжилтийг хүлээн авсан байна.

Тайлант онд 423,953.7 мянган төгрөгийг зарцуулж, 54,573.9 мянган төгрөгийг Сангийн яамны төрийн санд татан төвлөрүүлж ажилласан байна.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд байршуулбал зохих 149 мэдээллээс 140 мэдээллийг хугацаанд нь оруулсан, 7 мэдээлэл хугацаа хоцроосон, 3 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулаагүй байна.

ЮНЕСКО-ийн Монголын үндэсний комисс нь төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбар, хандив, тусламжийн хэмжээ, түүний зарцуулалтын тайланг бүтэн жилээр нь мэдээлэх шаардлагатай ч шилэн дансны цахим хуудсанд огт байршуулаагүй байна.

Тайлант онд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 666,747.9 мянган төгрөгийн орлого, 218,172.0 мянган төгрөгийн зарлагын гүйлгээг мэдээлсэн байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 14,559.0 мянган төгрөгийн зөрчлийг арилгах зөвлөмж, Үндэсний аудитын газрын 2020 оны 2 дугаар сарын 28-ны өдрийн 02/27 тоот албан шаардлагыг бүрэн биелүүлж ажилласан талаар ЮНЕСКО-ийн Монголын үндэсний комиссын 2020 оны МҮК/20/172 тоот албан бичгээр холбогдох газруудад хүргүүлсэн байна.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

/мянган.төг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	-	-	-	-	-	-	-
Албан шаардлага	1	12,897.8	1	12,897.8	0	0	100%
Зөвлөмж	2	1,661.2	2	1,661.2	0	0	100%
Нийт дүн	3	14,559.0	3	14,559.0	0	0	100%

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар илэрсэн нийт 590.7 мянган төгрөгийн алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх талаар 3 зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын залруулах аливаа зөрчил гараагүй болно.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар 590.7 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 1 албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

1. Шилэн дансны цахим сайтад 2020 оны 1 дүгээр сард 4 мэдээллийг, 3 дугаар сард 1 мэдээллийг, 4 дүгээр сард 1 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан нь Шилэн дансны тухай хуулийн 4.1.3-т “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх” заалттай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэх

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Төсөл, хөтөлбөрийн хүрээнд нэмэлт санхүүжилтээр орж ирж буй хөрөнгийн зарцуулалт, үр дүн, үр өгөөж, хэрэгжилтэд тавих хяналтыг авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Зардлын данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

ЮНЕСКО-ийн Монголын үндэсний комисс нь унаа хоолны зардлыг хэрхэн олгох талаар байгууллагын дотоод журам болон холбогдох шийдвэрт тусгалгүйгээр албан хаагчдад унаа, хоолны хөнгөлөлт хэлбэрээр олгосон байна.

1.2. Эрсдэл:

Төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах, холбогдох хууль, тогтоол, шийдвэрийг мөрдөж ажиллаагүй байх;

1.3. Өгсөн зөвлөмж:

Төрийн албаны тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.8-д “хууль тогтоомжид заасан бусад нөхөх төлбөр”, Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам”-ын 8.4-т “Төрийн албан хаагчийн өдрийн хоолны зардлын тодорхой хэсгийг байгууллагаас нөхөн олгоно” гэж тус тус заасныг хэрэгжүүлж ажиллах.

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлж, алдаа зөрчлийг давтан гаргахгүй ажиллана.

2. Авлагын данстай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Санхүүгийн байдлын тайланд онд 590.7 мянган төгрөгийн хувь хүмүүсээс авах авлагын үлдэгдэлтэй байна.

2.2. Эрсдэл:

Төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах;

2.3. Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, 16 дугаар зүйлийн 16.5.1-д “Төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах” гэж тус тус заасныг хэрэгжүүлж ажиллах.

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлж, алдаа зөрчлийг давтан гаргахгүй ажиллана.

3. Гадаад томилолттой холбоотой асуудал

3.1. Илрүүлэлт:

Гадаад томилолтоор ажилласан ажилтан, албан хаагчдаас томилолтын удирдамж, төлөвлөгөөг биелүүлсэн эсэхийг хянах зорилгоор томилолтын үр дүнг дүгнэж, тайланг аваагүй байна.

3.2. Эрсдэл:

Төрийн албаны тухай хууль, Засгийн газрын тогтоолыг хэрэгжүүлэхгүй байх;

3.3. Өгсөн зөвлөмж:

Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам”-ын 2.7-д “Төрийн албан хаагч хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр томилолтын удирдамж, төлөвлөгөөнд заасан үүргээ биелүүлээгүй бол томилолтоор ажиллах үеийн нөхөх төлбөрийг бүрэн, эсхүл тодорхой хувийг түүний шууд захирагдах нэгжийн удирдлагын саналыг үндэслэн буцаан төлүүлж болно” гэж заасныг хэрэгжүүлж ажиллах.

3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлж, алдаа зөрчлийг давтан гаргахгүй ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо: 2021	Аудитын нэр: ЮНЕСКО-ийн Монголын үндэсний комиссын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код: САГ-2021/336/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр: ЮНЕСКО-ийн Монголын үндэсний комисс	Мянган төгрөг	

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Унаа хоолны зардлыг хэрхэн олгох талаар байгууллагын дотоод журам болон холбогдох шийдвэрт тусгалгүйгээр албан хаагчдад унаа хоолны хөнгөлөлт хэлбэрээр олгосон байна.	-	Зөвлөмж өгөх	Ерөнхий нарийн бичгийн дарга Ерөнхий нягтлан бодогч	С.Уянга А.Алтантуяа
2	Хувь хүмүүсээс авах авлагын үлдэгдэлтэй байна.	590.7	Зөвлөмж өгөх	Ерөнхий нарийн бичгийн дарга Ерөнхий нягтлан бодогч	С.Уянга А.Алтантуяа
3	Тайлант хугацаанд байршуулбал зохих 149 мэдээллээс 140 мэдээллийг хугацаанд нь оруулсан, 7 мэдээлэл хугацаа хоцроосон байна.	-	Албан шаардлага өгөх	Ерөнхий нарийн бичгийн дарга Ерөнхий нягтлан бодогч	С.Уянга А.Алтантуяа
4	Гадаад томилолтоор ажилласан ажилтан, албан хаагчдаас томилолтын удирдамж, төлөвлөгөөг биелүүлсэн эсэхийг хянах зорилгоор томилолтын тайлан, мэдээ аваагүй байна.	-	Зөвлөмж өгөх	Ерөнхий нарийн бичгийн дарга Ерөнхий нягтлан бодогч	С.Уянга А.Алтантуяа
ДҮН		590.7			



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 02 дугаар сарын 24

№ 16/АОП0076

Улаанбаатар хот

СМТ- 2021/336 /СТА-ПЦЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн ЮНЕСКО-ийн Монголын үндэсний комиссын 2020 оны санхүүгийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Байгууллагын шилэн дансны цахим хуудсанд байршуулах 149 мэдээллээс 7 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 4.1.3-т “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх” гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг-таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны тухай хууль тогтоомжийн дагуу мэдээллийг үнэн зөв, ил тод байршуулж, биелэлтийг 2021 оны 6 дугаар сарын 10-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг ЮНЕСКО-ийн Монголын үндэсний комиссын ерөнхий нарийн бичгийн дарга С.Уянга, нягтлан бодогч А.Алтантуяа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:


АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

АУДИТОР
“АЗУРЕ ХҮЛҮГ АУДИТ” ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

С.ОТГОНХОРЛОО

Г.МӨНХБАЯР



Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

\\10.10.10.20\Bichig_Kherig\Alban_Shaardlaga\2021\0225auditin 2-R_Gazar2.Docx

001081018